

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:

“3.1.9.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт:

“6.2.8.Актив удирдлагын компанийн чиглэлээр Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дахь заалтын дугаарыг “3.1.10” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 197.9 дэх хэсгийн “Нэг” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 75.3 дахь хэсгийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.11 дэх заалт нэмсүгэй.

"14.2.11.Эцсийн өмчлөгчийн мэдээлэл."

2 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14-ийн "ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа" гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэг:

65.4.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн гаргасан нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх шүүгчийн захирамж, шүүхийн гүйцэтгэх хуудас гарсанаас хойш 10 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хөрөнгийн албадан дуудлага худалдаа явуулах тогтоол гаргана.

2/66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг:

66.3.Энэ хуулийн 65.4-т заасан албадан дуудлага худалдаа явуулах ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гарснаас хойш дуудлага худалдааг 30 хоногийн дотор зохион байгуулна.

3/75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг:

75.4.Иргэний хуулийн 177.2-д заасан анхны дуудлага худалдаанд оролцогч ирээгүй үндэслэлээр зохион байгуулах хоёр дахь дуудлага худалдаанд нэг оролцогч оролцож болно.

2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийн дугаарыг "66.4" гэж, 66.4 дэх хэсгийн дугаарыг "66.5" гэж, 66.5 дахь хэсгийн дугаарыг "66.6" гэж, 75 дугаар зүйлийн 75.4 дахь хэсгийн дугаарыг "75.5" гэж, 75.5 дахь хэсгийн дугаарыг "75.6" гэж, 75.5 дахь хэсгийн "75.4-т" гэснийг "75.5-т" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 41.1.16 дахь заалт нэмсүгэй.

“41.1.16.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компаниас гаргасан нэхэмжлэл.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

10

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Хөгжлийн банк" гэсний дараа "Монгол Улсын Актив удирдлагын компани," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.1.6 дахь заалт нэмсүгэй.

"7.1.6.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбоотой төлбөрт тооцон шилжүүлэн авсан болон худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТӨГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн 12.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 12.1.8 дахь заалт нэмсүгэй.

“12.1.8.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан Актив удирдлагын компанийн банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг шийдвэрлэхтэй холбоотой өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан орлого, газар өмчлөх эрх, газар эзэмших эрх, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, хуульд заасан бусад эрхийг борлуулсны орлого.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

"4.1.14."эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.

2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт:

"6.2.8.эцсийн өмчлөгчийн мэдээлэл;"

2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6.2.8, 6.2.9 дахь заалтын дугаарыг "6.2.9, 6.2.10" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар бүлэг “Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил”-д доор дурдсан агуулгатай 10.29 дүгээр зүйл нэмсүгэй.

“10.29.Актив удирдлагын компанийн тухай хууль зөрчих

1.Актив удирдлагын компанийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Актив удирдлагын компанийн тухай хуульд заасан хяналт шалгалтын болон бусад эрх бүхий байгууллагын хууль ёсны шийдвэр, шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй.

“6/ энэ хуулийн 23.2.1-т заасны дагуу шилжүүлэн авсан чанаргүй зээлийг актив удирдлагын компанид шилжүүлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Актив удирдлагын компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг